



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/А98

Булган сум

┌ Теле камерын хяналтын дэд төв ┐
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 86 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн III/12 дугаар тогтоолын хавсралтын 1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Булган сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих чиг үүрэг бүхий "Теле камерын хяналтын дэд төв"-ийг Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулсугай.

2. "Теле камерын хяналтын дэд төв"-ийг Тохижилт үйлчилгээний ангиас аймгийн Засаг даргын Тамгын газарт балансас балансад шилжүүлсэн "Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн"-гийн тоглоомын төвийн барилгад байрлуулсугай.

3. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6324011186